

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2019 ОНЫ ТОВЧ МЭДЭЭ

2019 оны 12 дугаар сарын 12

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа. Тухайлбал:

- Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдөр төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолыг төв, орон нутаг дахь газруудад зохион байгуулж, 5 албан хаагч тангараг өргөсөн.

- Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг 5 албан хаагчид олгосны дагуу зэрэг дэвийн нэмэгдлийг тооцож эхэлсэн.

- Байгууллагын даргын 2019 оны А/112 дугаар тушаалаар “Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлах” ажлын хэсгийг байгуулж, нийт 6 удаа хуралдаж, төрийн захиргааны 52 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан бусад баримт бичгийн хамт салбар зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 24-ний 17 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хянуулахаар хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 57 дугаар тогтоол гарснаар төрийн захиргааны 52 албан тушаалын тодорхойлолтыг байгууллагын даргын 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар баталсан. Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3.2-т заасныг үндэслэн төрийн үйлчилгээний 32 албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг байгууллагын даргын 2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/345 дугаар тушаалаар баталсан.

- 2019 оны 1-03/11 дүгээр удирдамжийн дагуу Виз, зөвшөөрөл харьяатын газрын мэдээллийн төвийн мэргэжилтний ажлын чиг үүрэг, ажлын ачааллыг тодорхойлохоор ажлын байрны зураг авалтыг хийсэн.

- Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны холбогдох тайлан, төлөвлөгөөний биелэлт, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын төлөвлөгөөний биелэлт, 2018 онд төрийн жинхэнэ албанаас түр чөлөөлөгдсөн иргэний нөөцийн бүртгэл, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн тухай мэдээ, төрийн байгууллагад хууль тогтоомж, зөрчсөн үйлдлийг арилгуулах талаар зохион байгуулсан ажил зэргийг 2019 оны 02 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлд тус тус хүргэсэн.

- Сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзоригт 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 22 дугаар албан бичгээр хүргүүлснээр Төрийн албаны зөвлөлөөс зарыг 10 дугаар сарын 11-ний өдөр [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn) цахим хаягаар олон нийтэд зарласан. Тус зарыг байгууллагын [immigration.gov.mn](http://immigration.gov.mn) цахим хуудас болон Гадаадын иргэн, харьяатын газрын цахим сүлжээнд тус тус байршуулж олон нийтэд мэдээлснээс гадна орон нутагт ажиллаж буй төрийн албан хаагчдаас бүртгэлд хамруулж хамтран ажиллах тухай Төрийн албаны зөвлөлийн Дундговь болон Дорнод аймаг дахь салбар зөвлөлд 10 дугаар сарын 14-ний өдрийн 24, 25 дугаар албан бичгийг хүргүүлсэн. “Гүйцэтгэх албан

тушаалын сул орон тоог нөхөх шалгалтын комиссыг байгуулах тухай” 10 дугаар сарын 14-ний өдрийн 02 дугаар тогтоол гарч, комисс 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажилласан. Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын дагуу Төрийн албаны зөвлөлийн сургалтын танхимд 10 дугаар сарын 29-ний өдөр тусгай шалгалтыг зохион байгуулж, шалгалтын комиссын тайлан, дүгнэлтийг нэгтгэн салбар зөвлөлийн 11 дүгээр сарын 01-ний өдрийн 03 дугаар хурлаар хэлэлцүүлсэн.

- Сул орон тооны сонгон шалгаруулалтын дараагийн шатны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзоригт 2019 оны 10 сарын 25-ны өдрийн 22 дугаар албан бичгээр хүргүүлснээр Гадаадын иргэн, харьяатын газрын гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын зар Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд 11 дүгээр сарын 11-ний өдөр тавигдсан. Гэвч Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 309 дүгээр тогтоолоор байгууллагын салбар зөвлөлийг хүчингүй болгосон тул тус шалгалтыг түр тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан.

Төрийн албаны зөвлөлд байгууллагын 2019 оны 04 дүгээр сарын байдлаар чөлөөлөгдсөн, шилжин томилогдсон, сул орон тооны судалгааг Төрийн албаны тухай хуулийн 27.2-т заасны дагуу 2019 оны 14 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагааны 2019 оны эхний хагас жилийн тайлан, төлөвлөгөөний биелэлт, төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн бүртгэл, өргөдөл гомдлын судалгааг Төрийн албаны зөвлөлд салбар зөвлөлийн 2019 оны 18 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

Төрийн албаны хүний нөөцийн программд шинээр томилогдсон 14, албан тушаал өөрчлөгдсөн 3, чөлөөлөгдсөн 18 албан хаагчийн мэдээллийг нөхөн оруулснаас гадна давхардсан тоогоор төвийн 220 албан хаагчийн цалингийн нэмэгдлийг, орон нутаг дахь газрын захиргааны ахлах мэргэжилтнүүд тус тусын газрын 266 албан хаагчийн мэдээллийг программд бүртгэсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу төвийн 118, орон нутаг дахь газрын 160 нийт 278 албан хаагчийн хувийн баяжилтыг шинэчлэн хавтсыг сольж, 109 удаагийн баяжилт хийсэн.

2019 оны 5 дугаар сарын 17-ны өдөр “Төрийн албаны нөөц бүрдүүлэх журам” сэдвээр Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газрын хүний нөөцийн бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн О.Болор-Эрдэнэ, “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” сэдвээр Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сан хариуцсан мэргэжилтэн Б.Гончигсумлаа нарыг урьж төв, орон нутаг дахь газруудад цахим сургалтыг зохион байгуулсан.

2019 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс хамтран “Эрх зүйн шинэтгэл, хүний нөөцийн удирдлага” сэдвээр зохион байгуулсан сургалтад хүний нөөц хариуцсан мэргэжилтэн хамрагдсан.

Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооноос Европын холбоо болон Нэгдсэн Үндэстний байгууллагатай хамтран 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулсан “Ажлын байр-Дарамтгүй орчин” хэлэлцүүлэгт тус байгууллагын Захиргаа, удирдлагын газрын дарга, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн нар оролцсон.

Удирдлагын академиас зохион байгуулсан ахлах түшмэлийн сургалтад 2 албан хаагч, эрхэлсэн түшмэлийн сургалтад 8 албан хаагч тус тус хамрагдсан.

Төрийн албаны зөвлөлөөс 12 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд “Хуулиа дээдэлсэн, иргэдээ эрхэмлэсэн төрийн албаны төлөө” сэдэвт нэгдсэн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн оролцож, төрийн албаны шинэтгэлийн бодлого, хүний нөөцийн аудит, маргаан хянан шийдвэрлэх, жендэрийн эрх тэгш байдал болон технологийн шинэчлэл бүтээлч сэтгэлгээний чиглэлээр олон талын мэдээлэл авсан.

Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 3 удаа хуралдаж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэж ажилласан бөгөөд салбар зөвлөлөөс 26 албан бичиг гадагш явж, 24 албан бичиг ирсэн. Мөн иргэнээс 1 гомдол ирснийг хугацаанд нь шийдвэрлэж ажилласан.

## САЛБАР ЗӨВЛӨЛ